



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 27 -ны өдөр

Дугаар А/87

Эрдэнэт

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл  
байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7, 40 дүгээр зүйлийн 40,1 дэх заалт, Монгол улсын засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Дүрэм батлах тухай” 33 дугаар тогтоол, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Эрүүл мэндийн газрын “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх, журмыг хэрэгжүүлэх, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулж, тайлан мэдээг тогтоосон хугацаанд нь гаргаж байхыг зөвлөлийн дарга /П.Отгонбилэг/-т даалгасугай.
3. Тушаалийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/45 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын  
2022 оны 09 сарын 27 өдрийн  
1/4 дугаар тушаалын хавсралт



Төрийн албан хаагчийн ёс зүйн  
зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга:

П. Отгонбилэг - Дархлаажуулалт, зоонозын халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичиг:

М. Бямбасүрэн - Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Г. Энхжаргал - Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн

С. Мөнхзул - Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал урамшуулал хариуцсан мэргэжилтэн

Г. Нарандарь - Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн